



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/547

Арвайхээр

Гэрээ шууд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, (COVID-19) цар тахлын халдвар дотоодод илэрсэнтэй холбогдуулан аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд (COVID-19)-ийн шинжилгээ хийх Молекул биологийн лабораторийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмжийн чанар, стандартад хяналт тавьж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Д.Мөнхнасан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101247